



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 104

Номгон

Залуучуудын хөгжлийг дэмжих талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Залуучуудын нийгмийн идэвх оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, манлайлах ур чадварыг эзэмшүүлэх цогц үйл ажиллагааг сум бүрд зохион байгуулах удирдамж боловсруулан баталж, шаардлагатай төсөв хөрөнгийг гаргаж хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

2. Дээрх үйл ажиллагааг сумдад зохион байгуулахад удирдлага, арга зүйгээр хангаж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Тэргүүлэгчдийг оролцуулан хамтран ажиллахыг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190175